

МОНГОЛ УЛС  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО  
ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар  
хот

Зарим хувьцаат компанийн үнэт цаасыг бүртгэлээс  
хасах, шинээр бүртгэх тухай

Үнэт цаасны тухай хууль батлагдахаас өмнө шүүхийн болон компанийн гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн үнэт цаасыг нь биржийн бүртгэлээс хассан нь Бүртгэл санхүү хөрөнгө оруулалтын хэлтсээс хийсэн шалгалтаар тогтоогдсон тул Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1."Сэлэнгэ", "Арав", "Гуулин тал", "Цэцэрлэг" ХК-иудыг сум дундын шүүхийн шийдвэрээр дампууруулсан, гишүүдийн хурлын шийдвэрээр "Шарга" ХК-ийг биржийн жагсаалтаас 1995 онд хассан тул дээрх компанийн үнэт цаасыг үнэт цаасны зах зээл дээр худалдахаар зөвшөөрсөн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлээс хассугай.

2.Гишүүдийн хурлын шийдвэрээр "Уян","Угалз" ХК нэгдэн "Монгол савхи"ХК болсон, " Чандмань барилга", "Суварган" ХК нэгдэж "Моннаб" ХК болсон, "Хаалга", "Цонх" ХК нийлж "Хаалга цонх" ХК болсон, "Эрдэнэт хангай", "Хялганат" ХК нэгдэж "Хялганат" ХК болсон, 1996 онд "Үдлэгийн гэгээ" ХК нь бүх гишүүдийн хурлаар ХХК болж өөрчлөгдсөн тул хуучин ХК-ийн үнэт цаасыг үнэт цаасны зах зээл дээр худалдахаар зөвшөөрсөн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлээс хасах, шинээр үүссэн ХК-ийн үнэт цаасыг дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэхийг Ажлын алба /Ж.Жадамбаа/-д даалгасугай.

3.Биржийн өдөр тутмын хэвлэлээр мэдээлдэг үнэт цаасны арилжааны мэдээнд үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэгдсэн бүх хувьцаат компанийн нэрсийг оруулж, Хорооны шийдвэрээр арилжааг нь түр зогсоосон компанийн нэрийн ард тэмдэглэл хийж нийтэлж байхыг Хөрөнгийн бирж /О. Энхбаяр/-д үүрэг болгосугай.

4. Хорооны шийдвэрийн дараа биржийн үнэт цаасны жагсаалтаас холбогдох компанийн үнэт цаасыг хасч байхыг Хөрөнгийн бирж /О.Энхбаяр/-д даалгасугай.

5.Дээрх тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/, Хөрөнгийн бирж /О. Энхбаяр/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН